

# ХААН СОЁМБО АУДИТ ХХК



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Далайн-Элбэрэлт Өрхийн Эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/221/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг  
2022 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Аудитор: Г.Ичинхорлоо  
Утас: 88688168 Цахим хаяг: [ichinkhorloog@audit.gov.mn](mailto:ichinkhorloog@audit.gov.mn)

Хаан соёмбо аудит ХХК-ын захирал: Х.Диймаа  
Утас: 99065668 Цахим хаяг: [info@khaansoyomboaudit.mn](mailto:info@khaansoyomboaudit.mn)

Гүйцэтгэсэн аудитын менежер: Л.Марсаржалам  
Утас: 88114867 Цахим хаяг: [khaan.soyombo.audit@gmail.com](mailto:khaan.soyombo.audit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ.....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	14
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	14
3.5.3 Нэмэлт төсөв.....	15
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн.....	15
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	17
5.1 Төлбөрийн акт.....	17
5.2 Албан шаардлага.....	17
5.3 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	18

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

᠒᠐᠒3.0᠗.᠒4 № ᠐1/᠒᠒᠒᠒  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ДАЛАЙН  
ЭЛБЭРЭЛТ ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ТӨВИЙН ДАРГА Ц.БУЯННЭМЭХ ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Далайн Элбэрэлт Өрхийн эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Өрхийн Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 15-ны А/212 тоот тушаалаар батлагдсан Өрхийн эрүүл мэндийн төвийн үлгэрчилсэн дүрмийг мөрдлөг болгон ажилладаг. Өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх өрхийн эрүүл мэндийн төвийн баг нь нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан хуулийн этгээд байна гэж тус үлгэрчилсэн дүрэмд заасан байна. Нөхөрлөлийн хэлбэрээр байгуулагдсан төв нь дараах зохион байгуулалттай байна. Үүнд:

- Тухайн төвд ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтний 70-аас доошгүй хувь нь нөхөрлөлийн гишүүн байна.
- Төвийн удирдлага нь нөхөрлөлийн бүх гишүүдийн хурал байна

гэж заасан ба төвийн төсөв хөрөнгө хэрхэн зарцуулах талаар мөн нөхөрлөлийн гишүүдийн хурлаар шийдвэрлэдэг байна.

### Аудитын гол асуудал

Өрхийн эрүүл мэндийн төв нь өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж үйлчилгээг нэг иргэнээр тооцсон төлбөрийн аргаар санхүүждэг ба өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим тусламж үйлчилгээ нь тохиолдолд суурилсан төлбөрөөр санхүүждэг.

Тайлант хугацааны зардлыг түүвэрлэн үзэхэд цахим төлбөрийн /е–баримт/ баримтгүй 5,595.3 мянган төгрөгийн ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнасан байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь Аймгийн засаг дарга, Эрүүл мэндийн газрын даргатай гурвалсан гэрээ байгуулж 2022 онд 22 зорилтын хүрээнд 110 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж 90.5 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

СТ-1А

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>145,612,034.34</u></b>	<b><u>50,454,350.11</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	29,047.56	4,671,187.69
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	29,047.56	4,671,187.69
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	29,047.56	4,671,187.69
31211	Төрийн сангийн харилцах	29,047.56	4,671,187.69
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	108,964,313.00	00.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	108,964,313.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	36,618,673.78	45,783,162.42
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	15,696,497.30	23,157,085.94
35110	Тусгай зориулалттай материал	6,620,950.00	10,297,617.00
35130	Эм боох материал	9,075,547.30	12,859,468.94
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	20,922,176.48	22,626,076.48
35470	Бусад хангамжийн материал	20,922,176.48	22,626,076.48
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>487,284,655.18</u></b>	<b><u>491,745,867.25</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	487,284,655.18	491,745,867.25
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	467,145,155.18	471,646,471.44
39201	Барилга, байгууламж, орон сууц	379,077,926.09	379,077,926.09
39202	Хуримтлагдсан элэгдэл	-23,033,503.13	-32,672,149.61
39203	Авто-тээврийн хэрэгсэл	12,750,000.00	12,750,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-1,992,187.50	-3,585,937.50
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	52,656,545.10	88,288,099.78
39206	Хуримтлагдсан элэгдэл	-10,025,503.35	-25,575,769.31
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,263,399.82	11,263,399.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	-3,407,538.36	-4,515,484.66
39214	Бусад үндсэн хөрөнгө	54,413,853.00	54,413,853.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,557,836.49	-7,797,466.17
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	20,139,500.00	20,099,395.81
39301	Програм хангамж	137,500.00	137,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-40,104.19
39303	Бусад биет бус хөрөнгө	20,002,000.00	20,002,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>632,896,689.52</u></b>	<b><u>542,200,217.36</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>00.00</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>632,896,689.52</u></b>	<b><u>542,200,217.36</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	632,896,689.52	542,200,217.36
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	164,465,499.87	164,465,499.87
51101	Өмч: - төрийн	164,465,499.87	164,465,499.87
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	391,661,330.09	300,964,857.93
51210	Өмнөх үеийн үр дүн	391,661,330.09	391,661,330.09
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-90,696,472.16
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	76,769,859.56	76,769,859.56
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>632,896,689.52</u></b>	<b><u>542,200,217.36</u></b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,502,240,985.07</b>	<b>840,692,047.15</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>770,326,949.07</b>	<b>127,102,100.65</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	770,326,949.07	127,102,100.65
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	740,889,349.07	121,430,080.65
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	740,889,349.07	121,430,080.65
120009	Бусад орлого	29,437,600.00	5,672,020.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>402,288,230.00</b>	<b>713,589,946.50</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	329,625,806.00	00.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	402,288,230.00	713,589,946.50
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	402,288,230.00	713,589,946.50
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,375,707,690.13</b>	<b>931,388,519.31</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,375,707,690.13</b>	<b>931,388,519.31</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,300,066,512.13	914,654,740.31
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	373,379,177.30	635,293,231.00
210101	Үндсэн цалин	373,379,177.30	635,293,231.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	42,802,541.98	76,530,999.30
210202	Тэтгэмжийн даатгал	42,802,541.98	76,530,999.30
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	9,382,335.89	11,456,249.97
210301	Гэрэл, цахилгаан	1,257,712.04	1,363,219.15
210302	Түлш, халаалт	7,820,992.83	9,543,906.75
210303	Цэвэр, бохир ус	303,631.02	549,124.07
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	15,702,679.00	19,798,965.00
210401	Бичиг хэрэг	5,112,169.00	7,159,847.00
210402	Тээвэр, шатахуун	3,091,510.00	4,897,390.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,209,410.00	3,479,930.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	135,000.00	615,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,892,770.00	624,760.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,261,820.00	3,021,538.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	821,490,060.13	120,390,450.43
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	821,490,060.13	120,390,450.43
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,355,273.64	2,177,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	50,263.64	69,000.00
210604	Урсгал засвар	4,305,010.00	2,108,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	00.00	921,800.00
210702	Дотоод албан томилолт	00.00	921,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	257,218.00	715,702.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	350,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	33,936.00	73,436.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	22,000.00
210807	Газрын төлбөр	116,182.00	136,266.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	107,100.00	134,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	32,697,226.19	47,370,342.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,531,026.00	15,070,880.00

Хөвсгөл аймгийн Далайн-Элбэрэлт Өрхийн эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,440,500.00	1,129,120.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,725,700.19	31,170,342.61
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>75,641,178.00</b>	<b>16,733,779.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>75,641,178.00</b>	<b>16,733,779.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	75,641,178.00	16,733,779.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>126,533,294.94</u></b>	<b><u>-90,696,472.16</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>126,533,294.94</u></b>	<b><u>-90,696,472.16</u></b>

СТ-3А

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>657,177,502.00</u></b>	<b><u>828,226,279.50</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b><u>29,437,600.00</u></b>	<b><u>5,672,020.00</u></b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	29,437,600.00	5,672,020.00
120009	Бусад орлого	29,437,600.00	5,672,020.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b><u>627,739,902.00</u></b>	<b><u>822,554,259.50</u></b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	329,625,806.00	00.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	298,114,096.00	822,554,259.50
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5,290,179.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	292,823,917.00	822,554,259.50
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>646,318,307.17</u></b>	<b><u>813,254,139.37</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b><u>646,318,307.17</u></b>	<b><u>813,254,139.37</u></b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b><u>565,886,950.17</u></b>	<b><u>796,520,360.37</u></b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	373,379,177.30	635,293,231.00
210101	Үндсэн цалин	373,379,177.30	635,293,231.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	42,802,541.98	76,530,999.30
210202	Тэтгэмжийн даатгал	42,802,541.98	76,530,999.30
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	9,382,335.89	11,456,249.97
210301	Гэрэл, цахилгаан	1,257,712.04	2,267,474.15
210302	Түлш, халаалт	7,820,992.83	8,639,651.75
210303	Цэвэр, бохир ус	303,631.02	549,124.07
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	18,965,809.00	21,152,865.00
210401	Бичиг хэрэг	5,112,169.00	7,118,847.00
210402	Тээвэр, шатахуун	3,091,510.00	4,897,390.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,209,410.00	3,520,930.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	135,000.00	615,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,155,900.00	1,708,660.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	2,261,820.00	3,291,538.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	101,401,932.00	29,236,913.10
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	98,126,932.00	28,656,913.10
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,275,000.00	580,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,726,410.00	4,982,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,421,400.00	2,874,400.00
210604	Урсгал засвар	4,305,010.00	2,108,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	00.00	921,800.00
210702	Дотоод албан томилолт	00.00	921,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	257,218.00	705,902.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	350,000.00

**Хөвсгөл аймгийн Далайн-Элбэрэлт Өрхийн эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210804	Тээврийн хэрэгслийн татвар	33,936.00	73,436.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	22,000.00
210807	Газрын төлбөр	116,182.00	136,266.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	107,100.00	124,200.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>12,971,526.00</b>	<b>16,240,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,531,026.00	15,110,880.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,440,500.00	1,129,120.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>80,431,357.00</b>	<b>16,733,779.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>80,431,357.00</b>	<b>16,733,779.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,290,179.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	75,141,178.00	16,733,779.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>10,859,194.83</u></b>	<b><u>14,972,140.13</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>8,830,000.00</b>	<b>10,330,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>8,830,000.00</b>	<b>10,330,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>8,830,000.00</b>	<b>10,330,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,830,000.00	10,330,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-8,830,000.00</u></b>	<b><u>-10,330,000.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>2,029,194.83</b>	<b>4,642,140.13</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>30,252.73</b>	<b>29,047.56</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>29,047.56</b>	<b>4,671,187.69</b>

**СТ-4А**

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	144,463,499.87	-874,413.00	-30,858,623.94	112,730,462.93
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>144,463,499.87</b>	<b>-874,413.00</b>	<b>-30,858,623.94</b>	112,730,462.93
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	15,423,805.33	15,423,805.33
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>164,465,499.87</b>	<b>76,769,859.56</b>	<b>391,661,330.09</b>	632,896,689.52
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	<b>164,465,499.87</b>	<b>76,769,859.56</b>	<b>391,661,330.09</b>	632,896,689.52
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>164,465,499.87</b>	<b>76,769,859.56</b>	<b>391,661,330.09</b>	632,896,689.52
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-90,696,472.16	-90,696,472.16
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>164,465,499.87</b>	<b>76,769,859.56</b>	<b>300,964,857.93</b>	542,200,217.36

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>813,254,139.37</b>	<b>813,254,139.37</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>813,254,139.37</b>	<b>813,254,139.37</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>796,520,360.37</b>	<b>796,520,360.37</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>635,293,231.00</b>	<b>635,293,231.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210101	Үндсэн цалин	635,293,231.00	635,293,231.00	0.00	100.0
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>76,530,999.30</b>	<b>76,530,999.30</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210202	Тэтгэмжийн даатгал	76,530,999.30	76,530,999.30	0.00	100.0
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>11,456,249.97</b>	<b>11,456,249.97</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,267,474.15	2,267,474.15	0.00	100.0
210302	Түлш, халаалт	8,639,651.75	8,639,651.75	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	549,124.07	549,124.07	0.00	100.0
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>21,152,865.00</b>	<b>21,152,865.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210401	Бичиг хэрэг	7,118,847.00	7,118,847.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	4,897,390.00	4,897,390.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,520,930.00	3,520,930.00	0.00	100.0
210404	Ном, хэвлэл	615,500.00	615,500.00	0.00	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,708,660.00	1,708,660.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,291,538.00	3,291,538.00	0.00	100.0
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	29,236,913.10	29,236,913.10	0.00	100.0
2105	<b>Нормативт зардал</b>	<b>28,656,913.10</b>	<b>28,656,913.10</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	580,000.00	580,000.00	0.00	100.0
210502	Хоол, хүнс	4,982,400.00	4,982,400.00	0.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,874,400.00	2,874,400.00	0.00	100.0
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,108,000.00</b>	<b>2,108,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	921,800.00	921,800.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	921,800.00	921,800.00	0.00	100.0
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>705,902.00</b>	<b>705,902.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210701	Гадаад албан томилолт	350,000.00	350,000.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилолт	73,436.00	73,436.00	0.00	100.0
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>22,000.00</b>	<b>22,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	136,266.00	136,266.00	0.00	100.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	124,200.00	124,200.00	0.00	100.0

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,240,000.00	16,240,000.00	0.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,110,880.00	15,110,880.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,129,120.00	1,129,120.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,733,779.00	16,733,779.00	0.00	100.0
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	16,733,779.00	16,733,779.00	0.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,733,779.00	16,733,779.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	16,733,779.00	16,733,779.00	0.00	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	10,330,000.00	10,330,000.00	0.00	100.0
2200	Дотоод эх үүсвэрээр	10,330,000.00	10,330,000.00	0.00	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	828,226,279.50	828,226,279.50	0.00	100.0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	822,554,259.50	822,554,259.50		
140020	Бусад	5,672,020.00	5,672,020.00		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	29,047.56	29,047.56	0.00	100.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,671,187.69	4,671,187.69	0.00	100.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	0	0	0.00	0.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0.00	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23	23	0.00	100.0
620001	Удирдах ажилтан	20	20	0.00	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	0	0	0.00	0.0
620003	Үйлчлэх ажилтан	2	2	0.00	100.0
620004	Гэрээт ажилтан	0	0	0.00	0.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй.

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

#### *Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Хөвсгөл аймгийн Далайн-Элбэрэлт Өрхийн Эрүүл мэндийн төв нийгмийн эрүүл мэндийг тэргүүлэх чиглэлээ болгон эрүүл мэндийн болон мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг өргөжүүлэн иргэдийн сэтгэлд нийцсэн үйлчилгээ үзүүлэх зорилго тавьсан байна.

Далайн-Элбэрэлт Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүний нөөцийг мэргэшүүлэх, үйлчилгээний чанар сайжруулах
- Хүүхдийн суурь өвчлөлийг эмчлэн эрүүлжүүлэх
- Хүрч үйлчлэх тусламж үйлчилгээг зорилтот бүлгийн хүн амд зохион байгуулах
- Жирэмсний эрт илрүүлгийн хувийг нэмэгдүүлэх
- Өсвөр үеийнхэн болон ахмад настны урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах
- Хүн амын дунд эрүүл мэндийн боловсрол

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

#### **Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар**

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 8 дугаар сард эрүүл мэндийн салбарын багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулж, эрүүл мэндийн даатгалын цогц шинэчлэл хийх, стратегийн худалдан авалтыг бий болгох эрх зүйн орчин бүрдүүлсэн. Шинэчлэлийн хүрээнд 2022 онд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ бүрийн өртөг, зардлыг шинэчлэн тооцож, эрүүл мэндийн байгууллагуудыг үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлээр нь Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлж байна. Үүнтэй холбогдуулан Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр батлагдсан<sup>1</sup> 01,02 дугаар тогтоол, 2022 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр батлагдсан<sup>2</sup> тогтоолуудаар эрүүл мэндийн даатгалын багцын төлбөр хураамжийг нэмэгдүүлэн нэг иргэнд ногдох нормативаар, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ гэсэн арга хэмжээгээр санхүүжилтийг олгож байна.

Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Нөхөрлөлийн тухай хууль болон тэдгээрийн холбогдох бусад хууль тогтоомж, MNS 5292: 2017 “Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт” болон Эрүүл мэндийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 15-ны А/212 тоот тушаалаар батлагдсан Өрхийн эрүүл мэндийн төвийн үлгэрчилсэн дүрмийг мөрдлөг болгон ажилладаг. Өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх өрхийн эрүүл мэндийн төвийн баг нь нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан хуулийн этгээд байна гэж тус үлгэрчилсэн дүрэмд заасан байна. Нөхөрлөлийн хэлбэрээр байгуулагдсан төв нь дараах зохион байгуулалттай байна. Үүнд:

- Тухайн төвд ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтний 70-аас доошгүй хувь нь нөхөрлөлийн гишүүн байна.
- Төвийн удирдлага нь нөхөрлөлийн бүх гишүүдийн хурал байна гэж заасан ба төвийн төсөв хөрөнгө хэрхэн зарцуулах талаар нөхөрлөлийн гишүүдийн хурлаар шийдвэрлэдэг байна.

**Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:**

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн “Төрийн хэмнэлтийн тухай” хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ийн дагуу Далайн-Элбэрэлт Өрхийн эрүүл мэндийн төвийн даргын 2022 оны 01 сарын 03-ны өдрийн А/03 тоот тушаалаар дотоод

<sup>1</sup> “Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай”

<sup>2</sup> “Багц, төлбөрийн хэмжээ, журам батлах тухай”

хяналтын багийг 3 хүний бүрэлдэхүүнтэй баталсан ба дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журмыг хавсралтаар баталсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд 30 заалт бүхий ажлын төлөвлөгөө хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан, улиралд нэг удаа дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу эрхлэгч 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мөрөн сумын Далайн-Элбэрэлт Өрхийн эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

**Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:** Далайн-Элбэрэлт Өрхийн эрүүл мэндийн төв нь 2017 онд аймгийн санхүү төрийн сангийн хэлтсээс боловсруулсан улсын секторын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн, эрүүл мэндийн салбарын байгууллагуудын төсвийн шатлалд өөрчлөлт орсонтой холбоотой нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрийн байгууллагын үйл ажиллагаандаа тохируулан боловсруулах шаардлага тулгарч байна. Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Далайн-Элбэрэлт Өрхийн эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 90,696.4 мянган сая төгрөгөөр буюу 14.3 хувиар буурсан байна. Эргэлтийн хөрөнгийн дүн өмнөх оноос буурсан нь 108,964.1 мянган төгрөгийн авлага барагдсантай холбоотой.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	29.0	4,671.1	4,621.1
Авлага	108,964.3	0	-108,964.3
Бараа материал	36,618.6	45,783.1	9,164.5
Үндсэн хөрөнгө	487,284.6	491,745.8	4,461.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>632,896.6</b>	<b>542,200.2</b>	<b>-90,696.4</b>
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	164,465.5	164,465.5	0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>632,896.6</b>	<b>542,200.2</b>	<b>-90,696.4</b>

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данс өмнөх оноос нэмэгдэж, авлага данс буурсан үзүүлэлттэй байна. Үүнд:

1. Тайлант онд мөнгөн хөрөнгө данс 4,642.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь эрүүл мэндийн даатгалын сангаас хүлээн авсан санхүүжилтийн зарцуулагдаагүй үлдэгдэл байна.
2. Бараа материалын үлдэгдэл 9,164.5 мянган төгрөгөөр өссөн нь ажилчдын нормын хувцас болон тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай эмнэлгийн багаж хэрэгсэл худалдан авсан нь гол нөлөөг үзүүлсэн байна.
3. Үндсэн хөрөнгө данс 4,461.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 18,869.9 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, үндсэн хөрөнгийн элэгдэл 12,439.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь гол нөлөө үзүүлсэн байна.
4. Өмнөх оны Эрүүл мэндийн даатгалаас авах 108,964.3 мянган төгрөгийн авлага хаагдсан.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Эрүүл мэндийн даатгалын сангаас 1 иргэнээр тооцсон төлбөр болох 605,829.0 мянган төгрөг батлагдсанаас 594,290.2 мянган төгрөг авсан ба ба 4 багц тусламж үйлчилгээний гүйцэтгэлээр 67,924.6 мянган төгрөг, ковид-19 өвчний үед гэрийн тусгаарлалт болон дархлаажуулалтын санхүүжилт 51,375.0 мянган төгрөг авсан ба өмнө оны Эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага 108,964.3 мянган төгрөгийн авлага авсан.

**3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Өрхийн эрүүл мэндийн төв нь өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж үйлчилгээг нэг иргэнээр тооцсон төлбөрийн аргаар санхүүждэг ба өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим тусламж үйлчилгээ нь тохиолдолд суурилсан төлбөрөөр санхүүждэг.

2022 оны 4-р сараас 1 иргэнээр тооцсон төлбөрийн зардал нэмэгдсэн ба Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 828,226.2 мянган

төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр болон бусад орлогоор бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 823,584.1 мянган төгрөг буюу 98 хувьтай байна.

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Нэг иргэнээр тооцсон нормативаар	594,290.2	594,290.2	0.00	100.0%
2	Эрүүл мэндийн даатгалын сангаас үндсэн тусламж үйлчилгээ, ковидын санхүүжилт	233,936.0	229,293.9	4,642.1	99.4%
	Нийт	828,226.2	823,584.1	4,642.1	99.4%

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн орлого байхгүй болно.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Далайн-Элбэрэлт өрхийн эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан соёмбо аудитын ХХК-ийн захирал Х.Диймаа, аудитын менежер Л.Магсаржалам нар гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Далайн-Элбэрэлт Өрхийн эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хаан соёмбо аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 07 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2 сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,375,707.7 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 27,514.1 мянган төгрөгөөр,

гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 19,259.9 мянган төгрөгөөр тогтоосон.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй зүйл илрээгүй болно.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 16,923.6 мянган төгрөгийн 2 гүйлгээг дутуу мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дах заалтыг зөрчсөн байна.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байна.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Далайн-Элбэрэлт Өрхийн эрүүл мэндийн төвийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

2021 оны санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг түүвэрт хамруулан, аудит хийсэн санхүүгийн тайлангийн талаар бие даасан санал дүгнэлт гараагүй, акт, албан шаардлага зөвлөмж өгөөгүй болно.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Өрхийн эрүүл мэндийн төв нь өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх тусламж үйлчилгээг нэг иргэнээр тооцсон төлбөрийн аргаар санхүүждэг ба өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим тусламж үйлчилгээ нь тохиолдолд суурилсан төлбөрөөр санхүүждэг ба аж ахуйн нэгж, өрхийн эрүүл мэндийн төсвийн тайлан гэж 2 тайлан гаргадаг

байна. Төрийн санд харилцах дансгүй арилжааны банкны дансаар бүх гүйлгээг хийгддэг тул орлого, зардлыг эдийн засгийн ангиллаар хянах боломжгүй байна.

Эрүүл мэндийн тухай хуулийн 16.2, Өрхийн эрүүл мэндийн үлгэрчилсэн дүрмийн 1.1 дэх заалтуудад “Өрхийн эрүүл мэндийн төв нь хот суурин газрын хүн амд төрөөс үзүүлэх өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий сайн дурын үндсэн дээр бүртгүүлсэн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага байна” гэж заасан тул тус байгууллага нь санхүү, хөрөнгийн зарцуулалтад зөвхөн нөхөрлөлийн бүх гишүүдийн хурлын шийдвэрийг баримтлан ажиллаж байна.

Өрхийн эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль журмын заалтыг зөрчиж үр ашиг багатай зүйлд хөрөнгө зарцуулсан, баяр ёслол тэмдэглэх, бэлэг дурсгалын зүйл худалдан авах гэх мэт зүйлд 400.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. Мөн таван Өрхийн эрүүл мэндийн төвийн дунд санхүү хариуцсан нэг нягтлан бодогч байдаг ба төвүүд орон тооны няравгүй ажиллаж байна.

Иймд өрхийн эрүүл мэндийн төсвийн статаусын асуудлыг хууль эрх зүйн хүрээнд оновчтой болгож, хөрөнгө санхүүгийн үр ашгийг дээшлүүлэхэд дараагийн аудитаар онцгой анхаарч, холбогдох дээд шатны байгууллагуудад санал хүргүүлэх нь зүйтэй байна.

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай асуудал илрээгүй тул залруулга хийгдээгүй болно.

Аудитаар нийт 22,518.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 22,518.9 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

### **5.1 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### **5.2 Албан шаардлага**

Албан шаардлага өгөөгүй болно.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Худалдан авах ажиллагаатай холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Тайлант хугацааны зардлыг түүвэрлэн үзэхэд цахим төлбөрийн /е – баримт/ баримтгүй 5,595.3 мянган төгрөгийн ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд бүртгэж тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь заалттай нийцэхгүй байгаа ба иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Аж ахуйн нэгж, байгууллагуудаас худалдан авалт хийхдээ төлбөрийн е баримтаар баталгаажуулж анхан шатны баримт бүрдүүлж ажиллах.

#### **2. Шилэн данстай холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ 16,923.6 мянган төгрөгийн 2 гүйлгээг дутуу мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дах заалтыг зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд иж бүрэн оруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Е баримтгүй гүйлгээ хийсэн	1	5,595.3					1	5,595.3				
Дүн	1	5,595.3					1	5,595.3				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
6.4.5 Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ	1	16,923.6						1	16,923.6
Дүн	1	16,923.6						1	16,923.6

**АУДИТЫН ТАЙЛАНГ:**

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

БАТАЛГААЖУУЛСАН:

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:

Х.ДИЙМАА ОГНОО:

Л.МАГСАРЖАЛАМ ОГНОО:

